



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/331

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", "ж", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2020 оны 30 дугаар хурлын шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2020 оны 18 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгасан, шинэ коронавирус (КОВИД-19)-ийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд соёл, урлаг, спорт болон олон нийтийг хамарсан бүх төрлийн үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд түр хориглосугай.

Хоёр. Аймгийн хэмжээнд бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг 11 дүгээр сарын 11-ний өдрийн 13:00 цагаас 11 дүгээр сарын 13-ны өдрийг дуустал хугацаанд түр зогсоосугай.

Гурав. Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй газруудын зөвхөн архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд түр хориглосугай.

Дөрөв. Хот хоорондын нийтийн зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 13-ны өдрийг дуустал хугацаанд түр хориглосугай.

Тав. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ж.Мөнхчулуун), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), болон холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, удирдлага, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  О.БАТ-ЭРДЭНЭ



482010913